

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРҮҮД
(УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ТЭСВЭРТЭЙ, ТОГТВОРТОЙ МАЛ АЖ АХУЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ)-ИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд (Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж, ахуйг хөгжүүлэх төсөл)-ийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн тухай санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус ирүүлсэн болно.

Төсвийн байнгын хорооны 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Г.Тэмүүлэн, Ц.Даваасүрэн, Д.Өнөрболор нар төслийн хэрэгжилтийн талаар тодруулан асууж, уг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, зориулалт, шалгуур үзүүлэлтийн талаар саналаа илэрхийлсэн бөгөөд төслийг дэмжсэн талаарх санал, дүгнэлтээ ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Цэрэнпунцаг, М.Оюунчимэг, С.Чинзориг, Х.Булгантуяа, Д.Бат-Эрдэнэ нар шинээр зээл авах тохиромжгүй байгаа тухай, Төсвийн байнгын хорооноос энэ зээлийн гэрээний зориулалтыг өөрчлөх талаар тодорхой чиглэл өгч, зарим өөрчлөлтүүдийг хийх нь зүйтэй гэсэн байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцэж, дэмжээгүй талаарх санал, дүгнэлтээ ирүүлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар уг төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа, шалгуур үзүүлэлт, үр дүнгийн тухай, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр зээл авахыг дэмжиж байгаа боловч төслийн хуваарилалт, зарцуулалтад анхаарч сайжруулах, зээлийн санхүүжилтийг тодорхой, бодит зүйлд зарцуулах, эрчимжсэн мал аж ахуй, малын гоц халдварт өвчин, шүлхийтэй тэмцэх зэрэг үр дүнтэй ажлуудыг санхүүжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан уг зээлийн санхүүжилтийг малыг эрүүлжүүлэх, экспортыг дэмжих, малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулахад ашиглах нь зүйтэй гэсэн санал гаргав.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрүүд (Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл)-ийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫНХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН